

МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХООРОНДОХ ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ

*И.Энхболд**

1989 онд Зүүн Европын олон орнуудад ардчилалын хөдөлгөөн өрнөж өөрчлөлт, шинэчлэлийг хийж, олон коммунист орнууд БНСУ-тай дипломат харилцаа тогтоов. Тэр дундаа Солонгос, Монгол хоёр орны хооронд тогтсон дипломат харилцаа нь өвөрмөц онцлогтой байв. Учир нь XIV зууны эцсээр Юань гүрэн бий болсны дараа Солонгос, Монгол хоёр орны хооронд тогтсон харилцаа дахин сэргэсэн явдал юм.

Түүхийн улбаанаас аваад үзвэл Монгол, Солонгос туургатан олон зуун жилийн тэртээгээс олон талын хэлхээ холбоотой явж ирсэн. Бие, биеийн хэл, соёл, түүхийг судлаж, элч төлөөлөгч, эрдэмтэн мэргэдээ харилцан илгээж, ураг барилдаж байсан зэрэг өчнөөн олон баримтыг дурдаж болно. Энэ бүхэн эдүгээ бидэнд ажиглагдаж мэдрэгдэхээр ул мөрөө үлдээсэн юм. Монгол, Солонгос хүмүүс гадаад төрх, зан байдлаараа хоорондоо их төстэй байгаа зэрэг нь бидний өвөг дээдэс, элэнц хуланц олон зуун жилийн турш айл саахалт улс шиг ойр дотно аж төрж байсных бизээ. МЭ 479 онд Монголын Нирун улс Солонгосын тэр үеийн Гугурё улстай хэлэлцээр байгуулж харилцан тохиролцож үгсэж байсан удаа бий. Харин Монгол, Солонгосын харилцаа нь XII зууны эцэс, XIII-XIV зууны үеэс нэн тодорхой мэдэгдэх болсон байна. Ийм нэн эртнээс манай улстай баялаг уламжлалт харилцаатай байсан үндэстэн бол Солонгос юм.¹

1990-ээд оны эхнээс Монгол Улс Азийн улс гүрнүүдтэй хоёр талын харилцаа хөгжүүлэх, энэ тивийн орнуудын нийтлэг ашиг сонирхолыг хөндсөн асуудлыг хамтран шийдвэрлэхэд бололцооны хэрээр тус дөхөм үзүүлэх, тус бүс нутаг дахь олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох талаар харьцангуй идэвхтэй бодлого явуулж ирсэн юм. Ази, Номхон далайд шинэ түнштэй болох асуудал тухайн үеийн Монгол Улсын Ази руу чиглэсэн бодлогын хүрээнд БНСУ-тай харилцаа тогтоосон юм. Тэр үедээ БНСУ-тай харилцаа тогтоох санаачлагыг Монголын талаас анх гаргасан бөгөөд тэр нь яах аргагүй зоримог алхам байсан юм.

1990 оны хавар Монгол Улсын улс төрийн тогтолцоо ихээхэн хэврэгшиж эдийн засгийн хямрал улам гүнзгийрсэн байлаа. Улс төрийн байдал ерөнхийдөө тогтвортой гэж үзэж болохоор боловч улс төрийн

*И.Энхболд - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

шинэ нам хөдөлгөөн байгуулагдаж тухайн үеийн төр, засгийн газрын бодлого, үйл ажиллагааг шүүмжилж жагсаал цуглаан хийж байв.

Тухайн үеийн манай гадаад бодлогод үзэл суртал ноёрхож, Европын чиг баримжаа давамгайлж байлаа. Монгол Улс Ази тивийн олон оронтой ёс төдий харилцаатай, мөн заримтай нь үзэл сурталын ялгаанаас болоод огт харилцаагүй буюу хэвийн бус харилцаатай байв.

Манай улс БНСУ-тай 1990 оны 3 дугаар сарын 26-ны өдөр албан ёсоор дипломат харилцаа тогтоосноос хойш даруй 10 гаруй жил улиран оджээ.² Манай хоёр улсын харилцаа түүхийн жам ёсоор өгсөж уруудах, тасалдаж сэргэхийн аль аль нь байсан юм. Энэ хугацаанд манай хоёр орны харилцаа улам бүр өргөжин тэлж, харилцан ашигтай хамтын ажиллагаа маань өдөр ирэх тусам гүнзгийрсээр байгаа билээ. Ялангуяа улс төр, эдийн засаг, нийгэм, соёл боловсролын салбарт, энэ хэдхэн жилийн хугацаанд л гэхэд БНСУ нь манай гадаад дахь гол түнш орны нэг болсон юм.

Манай хоёр орны нам засгийн удирдлага, төр засгийн тэргүүнүүд төдийгүй багш, оюутан, албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ч хүртэл харилцан айлчилж, хоорондоо мэдлэг боловсрол, дадлага туршлагаа солилцож байгаа бөгөөд энэ байдал нь манай орны хөгжилд багагүй хувь нэмэр оруулж байгаа.

Бидний монголчуудын нийгэм, эдийн засгийн чанартай бэрхшээл зовлонг ойлгож чин сэтгэлээр тууштай дэмжиж байгаа орны нэг бол БНСУ юм. Монгол оронд хөгжлийн тусламжаар олон төсөл хэрэгжүүлж үр шимийг нь манай ард түмэн хүртэж байна. Манайхантай харилцахдаа биднийг өөрсөдтэйгөө ижил удам угсааны улс гэсэн байр сууринаас дотно ханддаг улс бол Солонгос юм.

1991 оны 10 дугаар сард Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат зарим яамдын сайд, төр засгийн удирдах албаны хүмүүсийн хамт БНСУ-д айлчилж байсан бөгөөд 1999 оны 5 дугаар сард БНСУ-ын ерөнхийлөгч Ким Дэ Жүн Монгол Улсад айлчилсан нь хоёр орны харилцаанд шинээ үеийг нээв.³

Энэ хугацаанд хоёр орны хооронд тогтсон дипломат харилцааг бататгах үндсэн дээр хоёр орны Гадаад харилцааны сайд нар, Парламентийн дарга, Ерөнхий сайд болон Яамдын сайд нар, улс төр, эдийн засаг, соёл, хэвлэл мэдээлэл, биеийн тамирын байгууллагуудын олон төлөөлөгчид, мөн мэргэжилтэн, санваартан, эмч, жуулчид зорчигчдын тоо өнөөдөр жилд дунджаар арван мянгад хүрсэн байна.

Солонгос хүмүүс Монголын талаар Чингисын эзэнт улсын хойч үе гэсэн ерөнхий төсөөллөөс өөр ямарч ойлголтугүй байв. Тэгвэл одоо манай хоёр орны харилцааны цар хүрээ улам өргөжин тэлж хамтран ажиллаж байгаа салбар олширлоо. Харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх чиглэлд нэлээд урагшилсан гэж үзэж болно. Харилцааны үндсэн зарчмуудаа тодорхойлсон. Энэ бол томоохон амжилт яриангүй мөн юм. Худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл үйлчилгээний явцад үүсдэг төрөл бүрийн харилцааг зохицуулдаг гэрээ, хэлэлцээрүүдийн нэлээдийг бүр 1990-ээд оны эхээр үндсэнд нь байгуулсан гэж хэлж болно. Энэ чиглэлийн ажил сүүлийн жилүүдэд мөн эрчимтэй өрнөв. Хоёр орны төр засгийн тэргүүн, Парламентийн дарга, Гадаад харилцааны сайд нар, түүнчлэн Парламент, Засгийн газрын гишүүд, улс төрийн намын удирдагч нар харилцан айлчилснаар харилцаа хамтын ажиллагаа бүхэлдээ тогтвортой хөгжих улс төр, сэтгэл зүйн таатай нөхцөл бүрдэж эхэлсэн гэж үзэж болно.

Тэр дундаа эдийн засгийн харилцаа маш эрчимтэй хөгжсөөр байгаа билээ. Тиймээс манай хоёр орны эдийн засгийн харилцааг товч авч үзвэл дараах байдалтай байна.

Худалдаа

1990-ээд оноос өмнө ялимгүй худалдаанаас өөр хамтын ажиллагаа гэх юм байгаагүй. Тэр жаахан худалдаагаа гуравдахь улсаар дамжуулж, нууж хааж хийдэг байсан гэвэл одоо үнэмших хүн ховор байж мэднэ.

Хоёр орны хооронд хамтын ажиллагаа хөгжихийн хирээр хоёр орны худалдаа эрчимтэй өргөжиж дипломат харилцаа тогтоохоос өмнө 1989 онд дөнгөж 600 мянган ам.доллар байсан бол 1992 он гэхэд 16 дахин нэмэгдэж 9.7 сая, 1998 онд 46.9 сая, 2002 онд 76.0 сая ам.долларт хүрч өссөн байна. Энэ хугацаанд хоёр орны худалдаа бараг 130 дахин өслөө.

Манай экспортод БНСУ-ын хувийн жин 2000 онд 0.6 хувь байсан бол 2001 онд 0.9 хувь болж, импортод 2000 онд 9.0 хувь байсан бол 2001 онд 9.7 болж тус тус өсчээ. Худалдааны эргэлтийг сая ам.доллараар харуулав. ⁴

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Экспорт	0.7	1.6	2.4	2.8	4.5	1.8	3.0	8.6	2.0	2.7	4.1	3.1
Импорт	8.1	8.1	3.8	6.8	21.3	16.2	20.5	37.7	34.7	54.4	58.3	72.9
Нийт	8.8	9.7	6.2	9.6	25.8	18.0	23.5	46.9	36.7	57.1	62.4	76.0

Импортын зах зээл, хэрэглээний чиглэл өөрчлөгдөж БНСУ-аас харьцангуй чанартай, хямд бөөний хүнсний болон өргөн хэрэглээний бараа, автомашиныг ихээр импортлох болсон. БНСУ-д хууль бусаар ажилладаг манай иргэдийн тоо эрс нэмэгдсэн, экспортын хувьд манай улсаас АНУ-д оёмол сүлжмэл бүтээгдэхүүн экспортлоход тооны хязгаарлалт байхгүй худалдааны тааламжтай нөхцлийг ашиглах зорилгоор БНСУ-ын бэлэн хувцасны жижиг үйлдвэрүүд олноор байгуулагдсантай холбогдон худалдаа өссөн байна.

Бүтээгдэхүүний төрлийг авч үзвэл экспортод зэсийн хүдэр, баяжмал 53 хувь, оёмол бэлэн бүтээгдэхүүн 6.3 хувь (бугын эвэр, малын дайвар бүтээгдэхүүн, үслэг арьс, зүсмэл материал, хонины ноос гэх мэт), импортод бэлэн хувцас үйлдвэрлэх зориулалттай нийлэг мяндсан даавуу 12.2 хувь, нийтийн тээврийн моторт хэрэгсэл 8.2 хувь, хөнгөн тэрэг 26.3 хувь, бусад хүнсний болон өргөн хэрэглээний бараа 53 хувийг тус тус эзэлж байна. Манай гадаад худалдаанд БНСУ нийт бараа эргэлтийн хэмжээ 8.4 хувийг эзэлж 5 дугаар байранд орж байна. Барааны бүтцэд 1994 оноос хойш онц тодорхой өөрчлөлт гараагүй байна.

Худалдаа манайд ихээхэн алдагдалтай хэвээр байгаа тул манай уул уурхай, ашигт малтмал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд тааламжтай нөхцлийг бүрдүүлж өгөх, ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд ноогдуулдаг хязгаарлалт, хорио цээрээ хөнгөвчлөх талаар Солонгосын талтай тохиролцох хэрэгтэй байна.

Бүс нутгийн эдийн засгийн хэлхээ холбоонд оролцох, үүний дотор Өмнөд хийгээд Хойд Солонгос, Монголын эдийн засаг, санхүү, ажиллах хүч, байгалийн баялгийг хослуулан ашиглах чиглэлээр хүчин чармайлтаа уялдуулж, Хойд Солонгост үзүүлэх хүмүүнлэгийн хийгээд хүнсний тусламжын хүрээнд Монголоос бараа нийлүүлэх боломжыг авч үзэхээр хоёр орны төрийн тэргүүнүүд хэлэлцэн тогтсон байна.

БНСУ ганцхан жилд ойролцоогоор 9.2 тэрбум ам.долларын уул уурхайн түүхий эд хэрэглэдэг гэсэн тооцоо байдаг. Түүний 80 орчим хувийг зөвхөн Латин Америк, Ойрхи дорнодын орнуудаас импортолдог. Гэтэл энэ бүс нутгуудаар улс төр, цэргийн байдал ямар билээ. Газар зүйн хувьд ойр дөт, улс төрийн хувьд тогтвортой зах зээл хэрэгтэй гэдгийг Солонгосын эрдэс баялгийн бодлого барьж байгаа хүмүүс уржинангийн есдүгээр сарын арван нэгний хэрэг явдлаас хойш цохож ярьж байгаа. Аль ч талаасаа харсан Монгол Улс ихээхэн боломжтой зах зээлийн нэг болж болно. Түүнээс гадна Солонгос улс

үхрийн шир импортлон гүн боловсруулалт хийдэг нарийн технологитой цөөн улсын нэг. Монгол үхрийн ширийг Солонгосын технологиор боловсруулахад боломжын бүтээгдэхүүн гарна.⁵

Солонгос хоорондын төмөр зам тун удахгүй холбогдож магадгүй болоод байна. Нөгөөтэйгүүр Умард Солонгосын Хасан төмөр замыг далайн эргээр Өмнөд Солонгосын төмөр замтай холбох асуудал яригдаж байна. Эдгээр төсөл хэрэгжсэнээр Монгол Улс БНСУ-тай эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах нөхцөл бололцоо их сайжирна. Монголын дорнод хилээс 37 км тавихад л Хятадын Рашаант өртөөтэй, улмаар Солонгос хоорондын төмөр замын сүлжээнд холбогдох боломжтой.

Иймэрхүү асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлж харилцааны бодлогодоо байршуулж, хэрэгжүүлэх арга замыг хайж болно. Шаардлагатай судалгаа хийж холбогдох орнуудтай санал соллоцож уулзалт ярилцлага зохион байгуулах зэргээр ажиллаж болно. Мөн техник эдийн засгийн үндэслэл ч хийх боломжтой.

Идэвхтэй хамтран ажиллаад 10 гаруй жил болоход БНСУ-аас худалдааны тааламжтай нөхцлийг нь аваагүй байна. Тээврийн тарифын асуудлыг шийдээгүй. Үүнээс үүдээд манайд импортоор орж ирж байгаа барааны 25 хувийг тээврийн зардал эзэлж байна, Сүүлийн үед худалдаа үнийн дүнгээр өссөн боловч манай алдагдал нэмэгдсээр байна.

Хөрөнгө оруулалт

1990 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд БНСУ-ын 380 гаруй дагнасан болон хамтарсан компани нийт 71.5 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт бүртгэгдээд байна. Эдгээрээс 30 хувь нь хамтарсан, 70 хувь нь Солонгосын 100 хувийн хөрөнгө оруулалттай компаниуд юм.

Дээрх үзүүлэлтээрээ БНСУ нь БНХАУ-ын дараагаар Монголд шууд хөрөнгө оруулагч хоёрдугаарх орон хөрөнгө оруулалтын гол түнш болоод байна. Давхар татвараас чөлөөлөх гэрээг Монгол Улс, БНСУ-ын хооронд 1992.04.17 байгуулсан. Манай улс дахь БНСУ-ын шууд хөрөнгө оруулалт, бүртгэгдсэн компаний тоог доор харууллаа.⁶

БНСУ-аас Монгол Улс дахь шууд хөрөнгө оруулалт (мянган ам.доллараар):

Геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа олборлолт-12.950, худалдаа нийтийн хоол-9.007, хөнгөн үйлдвэр-6.709, тээвэр-5.771, харилцаа холбоо-5.268, үйлдвэрлэл-4.297, соёл урлаг, боловсрол,

шинжлэх ухаан, хэвлэл-1.698, эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ-1.566, мебель, модон эдлэл-1.143, ХАА, газар тариалан, МАА-1.100, үнэт зүйлс, бэлэг дурсгал-737, аялал жуулчлал-717, нийтийн ахуйн үйлчилгээ-474, эрчим хүч-468, хүнсний бүтээгдхүүний үйлдвэрлэл-447, гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл-117, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт-26, банк санхүүгийн үйл ажиллагаа-9, бусад-23.581, нийт-76.085

БНСУ-ын хөрөнгө оруулалттай компаний тоо:

Худалдаа нийтийн хоол -107, тээвэр-29, хөнгөн үйлдвэр-26, аялал жуулчлал-23, үйлдвэрлэл-21, эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ-19, нийтийн ахуйн үйлчилгээ-11, геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа олборлолт-10, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл-10, ХАА, газар тариалан, МАА-10, хүнсний бүтээгдхүүний үйлдвэрлэл-9, мебель, модон эдлэл-9, харилцаа холбоо-7, гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл-4, үнэт зүйлс, бэлэг дурсгал-2, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт-1, эрчим хүч-1, банк санхүүгийн үйл ажиллагаа-1, бусад-113 нийт 300 байгууллага байна.

Эндээс харвал Солонгосчууд бас манай уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгаа нь харагдаж байна. Монгол орныг Солонгосын хөрөнгө оруулагчидад таниулахад Солонгос дахь манай Элчин сайдын яам их анхаардаг. Тэд Солонгос, Монголын эрчим хүч, эрдэс баялгийн хамтын ажиллагаа сэдвээр Соул (Солонгос цагаан толгойн дуудлагаараа “соул” гэдэг) хотноо дугуй ширээний уулзалт зохион байгуулсан. Энэ уулзалтаас хойш хамтарч ажиллах сонирхол идэвхжиж байна. Ийм уулзалтыг өөр бусад салбарт хийх санаатай байгаа юм байна.

Монголын цахилгаан холбоо компанийн хувьцааны 40 хувийг 1995 онд Кореа Телеком компани худалдан авсан. SK Telecom, Taihan Electronics компаниуд 1999 онд үүрэн телефон холбоонд хөрөнгө оруулсан. Солонгосын Самсун корпораци Монголд 20 сая долларын хөрөнгө оруулалт хийж Улаанбаатарт 1000 айлын Самсун хороолол барихаа зарлав. Солонгосын нөөцийн нэгтгэл алтны хамтарсан хайгуул хийх газрыг Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Гичгин гэдэг газар сонгосон. CJ39, Самхуа компаниуд Монголд хөрөнгө оруулах сонирхолтойгоо илэрхийлээд байна.⁷

БНСУ-ын LG корпораци Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг хянах телекамерийн системийг суурилуулахад хамтарч ажиллана гэжээ. Энэ корпораци нь манай улсын Голомт банктай

хамтран ажиллаж 30 сая ам.долларын гэрээнд гарын үсэг зурсан ба Голомт банкны шинэ барилгыг хамгийн сүүлийн үеийн технологээр барьж байна. LG-INTERNATIONAL-ийнхан цаашдаа нийслэлийн болон манай улсын аялал жуулчлал, ашигт малтмал, барилгын салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөөд байгаа юм байна.⁸

Хөрөнгө оруулалтыг дан ганц гадныхан оруулж байна гэж үзэж болохгүй. Солонгост ажиллаж амьдарч байгаа манай иргэд зохих хуримтлалтай болсон, тэдэнд эх орондоо үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломжыг зориуд гаргаж өгөх асуудал байж болно. Иргэд хаана юунд хөрөнгө оруулахаа мэдэхгүй байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хувиараа хөдөлмөр эрхлэгчдын холбоо, Хувийн эздийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллага энэ чиглэлээр бодлого боловсруулж ажиллаж болох юм.

Хөрөнгө оруулалт хийж байгаа компаниуд ихэнх нь туршилтын, судалгааны шатанд явагдаж байгаа, тиймд хөрөнгө оруулалтыг илүү идэвхтэй хөгжүүлэхийн тул томоохон төслүүдэд чиглүүлэхээр ажиллах шаардлагатай.

2002 оны 3 дугаар сарын 19-нд Монгол, Солонгосын бизнесийн дугуй ширээний уулзалтыг Соүлд зохиож Монголд уул уурхай, эрчим хүч, газрын тосны чиглэлээр хөрөнгө оруулах талаар ярилцсан. 2002 оны 9-р сард Улаанбаатарт болсон хөрөнгө оруулагчдын зөвлөгөөнд Солонгосын 30 гаруй төлөөлөгч оролцож газар тариалан, уул уурхай, арьс шир, модны үйлдвэрлэл, жуулчин худалдааны салбарт хамтарч ажиллах түншээ олсон.⁹

Зээл тусламж

БНСУ бол манай хандивлагч орнуудын нэг. Монгол оронд өрнөсөн ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих үйл явцыг анхнаас нь бололцоотой бүхий л талаар дэмжиж ирснийг манайхан сайн мэднэ. Гал түймэр унтраахад хүч мөхөсдөхөд тусалж, цас зуд тохиолдсон хөдөө орон нутгийнханд ч тэд тусалж байлаа.

Солонгос улс 2000 он хүртэл 6 сая гаруй ам.долларын, 2000-2002 хүртээл 3.1 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлж хэрэгжүүдсэн байна.

Түүнчлэн EDCF-ийн мээдээнээс үзвэл энэг удаагийн тариурын үйлдвэр, дулааны цахилгаан станц барихад зориулж 14 сая долларын хөнгөлттэй зээл олгожээ.

Солонгосын олон улсын хамтын ажиллагааны шугамаар техникийн тусламж авч байгаа бөгөөд авч буй тусламжынхаа хэмжээгээр 1991 онд тусламж авдаг орнуудыг тэргүүлж байсан бол байр сууриа алдсаар 2002 онд 12 дугаар байранд орох болсон. Тусламжын хэмжээг доор мянган ам.доллараар болон эзэлж буй байраар нь үзүүлэв.¹⁰

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2002
Тусламж	1488	359	512	528	658	914	946	682	814	854
Байр	1	8	8	9	12	11	11	21	6	12

Өнөөдрийг хүртэл БНСУ 10413 сая вонын 20.32 сая ам.долларын зээл олгоод байна. Арханхангай, Өвөрхангайг эрчим хүчээр хангах Баянтээгийн ДЦС-ыг барьж байгуулахад 17.0 сая ам.долларын зээл авахаар ярилцаж байна.

Зээлийн хэлэлцээрийн өдөр, дугаар	Хэмжээ (саяар)	Хүү	Төлбөр хийх сар, өдөр		Үндсэн өргийн төлбөр		Зээлийн зориулалт
					эхлэх	дусах	
1993.11.24/MO N-1	KRW412 3.00	3.5	20/V	20/XI	1999.05.20	2013.05.20	Тариурын үйлдвэр
1997.06.09/MO N-2	KRW629 0.00	3.6	20/VI	20/XI	2002.06.20	2017.12.20	Даланзадгалын ДЦС
2006.09.09/MO N-2(SP)	USD0.72	3.1	20/VI	20/XI	2002.06.20	2017.12.20	Даланзадгалын нэмэлт
2000.09.09/MO N-3	USD5.3	2.1	20/III	20/IX	2011.03.20	2030.09.20	Төрийн холбооны сүлжээ
2000.09.09/MO N-4	USD14.3	1.1	20/III	20/IX	2011.03.20	2030.09.20	Зүүн аймгуудын шилэн кабель

БНСУ 10.1 сая ам.долларын буцалтгүй тусламж олгоод байна.

Үүнд:

Он	Хэмжээ (сая доллар)	Тусламжын зориулалт	
1993	6.0	Төр хурхийн үслэг ангийн аж ахуйд хөргүүрэн зоорь барих	0.4 сая
		Стандартчилал, хэмжил зүйн төвийн лаборатори байгуулах	
		Баянтээгийн ДЦС-ын судалгаа хийх	
2000	3.1	Шүүх эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах	0.4 сая
		Цусны төвийн тоног төхөөрөмжийг сайжруулах	0.3 сая
		Эрхтэн шилжүүлэх төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	0.24 сая
		Уламжлалт анагаах ухааны хамтарсан эмнэлэг байгуулах	0.4 сая
		Хамтарсан техникийн коллеж байгуулах	0.7 сая
		Ашигт малтмалын судалгаа хийх	0.5 сая
		Хүний нөөцийн хамтын ажиллагааг хөгжүүлэх	0.55
2001	1.0	Мэдээллийн байгуулах	инкубатор 1.0

БНСУ-аас үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламжын хүрээнд мэдээлэл холбооны тэргүүний технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний дэд бүтцийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх явдалд чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид энэ нь тэргүүлэх чиглэлүүд байхыг нотлов. Цаашид харилцаа холбооны сүлжээг боловсронгуй болгох төслийг зээлийн шугамаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1990-2001 оны хооронд БНСУ нь манай улсад 29 сая долларын хөнгөлттэй зээл олгоно гэж амласнаас одоо 10.6 сая буюу 36.6 хувийг нь олгоод байна.¹¹

2003 оны 11 сард хийсэн манай Ерөнхий сайдын айлчлалын үеэр Солонгосын тал манайд үзүүлэх 20 сая долларын хөнгөлттэй зээлийн хэмжээгээ бууруулахгүй гэдгээ мэдэгдэв. БНСУ-ын Засгийн газрын хөнгөлттэй зээлийг Чойр, Замын-Үүдийн авто замын төсөл, Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг хянах системийг сайжруулах төсөл, Улаанбаатар хотын цагдаа, түргээн тусламж, гал түймээртэй тэмцэх албадын холбоо, хяналт, мэдээллийн сүлжээг сайжруулах, их, дээд сургууль мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, Улаанбаатар хотын дулаан, ус дамжуулах төвүүдийн шинэчлэлтийн төсөл зэрэг Засгийн газрын тэргүүлэх ач холбогдол өгч буй төсөл төлөвлөгөөнүүдээд авч хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа манай тал илэрхийлсэн.¹²

КОИКА ээнэ онд манайд 954.5 мянган ам долларын тусламж үзүүлэх хөтөлбөр баталсан бөгөөд нийт тусламжын 66 хувь буюу 549300 ам.долларыг техникийн хамтын ажиллагаанд зориулж байна.

БНСУ-д ажиллаж амьдарч байгаа Монголын иргээдэд тусалцаа үзүүлэх Солонгосын УЗН-ын харьяа эмнэлгүүдээр монголын иргэдийг үнэ төлбөргүй эмчлэх болов. Тэдэнд 90 сая вонын үнэтэй 7500 ширхэг өвлийн хувцас нэг удаагийн буцалтгүй тусламж болгон олгов. Нийслэлийн Соүлийн гудамжыг тохижуулах ажилд солонгосын байгууллагууд сая орчим ам.долларын хөрөнгө зарцуулав.

Манай орны хувьд хамтын ажиллагааны харилцан ашигтай байдлын төвшинг дээшлүүлэх арга замыг хайх цаг болсон. Хамтын ажиллагааг дан ганц зээл тусламжаар хараад сурчихвал сайн юманд хүрэхгүй. Хамтран ажиллах тэр нуугдмал нөөц боломжыг эрж олох хэрэгтэй.

Хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалт, зээл тусламжын байдлыг товчхон дурдахад ийм байдалтай байна.

Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар Солонгосын буцалтгүй тусламжийн хүрээнд КОИСА болон хэрэгжүүлэгчээр нь KORES-тэй хамтран Дорнодын Баяндунгийн талбайд цайр, хар тугалганы ордуудын хайгуул, урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах төсөл, ШУА-ын Геологи, уул уурхайн хүрээлэнтэй хамтран Дорнодын Чойбалсангийн талбайд алт болон бусад ашигт малтмалын эрэл, судалгааны төсөл хэрэгжүүлж байна.¹³

Солонгосын компаниуд бусад хандивлагчдын зээл тусламжаар Монголд хэрэгжүүлж байгаа төслүүдэд амжилттай оролцсоор байна. Авто зам, барилгын салбарт Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжсэн авто зам хөгжүүлэх төслийн барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Санван корпораци ажиллаж Улаанбаатар-Дархан-Алтанбулагийн чиглэлийн автозамын засварыг хийсэн.

БНСУ-ын Ханжин групп манайд Боинг-727 онгоц бэлэглэж, 1997 оноос жил бүр манай 4-5 оюутанд тэтгэлэг олгож байна. КАЛ компаниас засварласан Боинг-727 онгоц хоёрыг зарим сэлбэгийн өртөг, нисэх бүрэлдэхүүн, инженер, техникчдийг давтан сургах зардал зэргийг оролцуулан нийт 5 сая ам.доллараар 1994 онд худалдан авч ашиглаж байна.

Арван жилийн өмнө Соул ороход Бээжингээс Токио, Гонконгийн аль нэгийг дамжиж хоёр хонож хүрдэг зам харилцааны бэрхшээлтэй байдал нөлөөлж зорчигчид ч цөөн байлаа. Харин одоо МИАТ компани 1994 оноос долоо хоногт 3 удаа, БНСУ-ын КАЛ компани 1996 оноос долоо хоногт нэг удаа хоёр улсын хооронд тогтмол нислэгтэй болсон. МИАТ компаний онгоц Соулээр дамжиж Япон руу нислэг хийж байна. Солонгост эмчлүүлэх гэсэн манай иргэдийн тоо огцом өсч байгаа бөгөөд яаралтай гэрээ хэлцэл хийх шаардлагатай байна. Ийнхүү хүмүүнлэгийн салбарын солилцоо өргөжих тутам онгоцны нислэг нэмэгдэж долоо хоногт Солонгосын онгоц нэг удаа, Монголын онгоц хоёр удаа нислэг хийж анхныхаасаа ихээхэн өөрчлөгдсөн.

2003 оны 11 дүгээр сарын 26-нд хийсэн Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалаар Солонгосын тал арилжааны нислэгийн 5 дугаар эрх олгох талаар нааштай хариу өгөв.

Ази, Европыг холбосон төмөр замын асуудал Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын төслийн хүрээнд яригддаг бөгөөд Монгол Улс уг төслийг сонирхож байна. Энэхүү төсөл хэрэгжвэл зөвхөн бүс нутгийн хөгжил цэцэглэлтэд төдийгүй манай улсын ирээдүйн хөгжилд чухал хөшүүрэг болно гэж үзэж байна.

Монгол Оросоос байгалийн хий, нефть дамжуулах хоолой болон Ази, Европыг холбосон төмөр замтай холбоход дэмжлэг үзүүлэхийг хүссэн байгаа. Монгол орны зүүн хэсэгт сансрын зураг ашиглан геологийн тогтолцооны судалгаа явуулах төсөл хэрэгжиж байна.

Энэ оны байдлаар БНСУ-д 16982 иргээн байгаагаас 15466 хүн хууль бусаар хөдөлмөр эрхэлж байна. Манай иргэдийн хөдөлмөрийн хөлс жилд (албан бус мэдээгээр) 6-12 сая ам.доллар байгаа нь багагүй хөрөнгө оруулалт төдийгүй зах зээлийн нөхцөлд амьдарч, хүнд бэрхийг үзэж, дадлага туршлага олж байгаагаараа ач холбогдолтой. Энэ бол манай улсын томоохон аймгийн төвийн хүн ам гэсэн үг юм. Ийм олон монгол хүн өөр хаана ч байхгүй. Хоёр орны хооронд Эрүүгийн хэргийн салбарт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулж, гэмт этгээдийг харилцан шилжүүлэх гэрээ үйлчилж байгаа.

Монголоос БНСУ-д гэрээгээр 900 хүн ажиллуулах квоттой байсан боловч илгээсэн хүмүүсийн ихэнх нь үйлдвэрээсээ оргож хувиараа ажил хөдөлмөр эрхэлсэн учраас квотоо ашиглах боломжгүй болсон. Гэрээгээр ирчихээд оргож хууль бус болдог бусармаг байдлыг зогсоох ёстой. Нөгөөтэйгүүр хүмүүсийг сонгож явуулдаг арга, механизмыг ч үндсээр нь солих цаг болсон. Сүүхээтэй хэдэн хүн гэрээ хийсэн болж ирээд оргодог. Түүнээс нь болоод улс квотоо ашиглах боломжгүй болдог. Харин 2003 оноос Солонгосын Засгийн газар манайхаас 3200 хүн ажиллуулахаар болж, үүнээс гадна ХАА-д 200 хүн нэмж авахаар болсон байна.¹⁴

Манай улс БНСУ-д хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа монгол иргэдийн ажиллах, амьдрах нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах, гэрээгээр ажиллах хүч оруулахад учирч байсан хориг саадыг арилгах гэсэн асуудалд онцгой анхаарч байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд ч энэ тал дээр түлхүү ажиллахыг хүсэж байгаа. Эхний асуудалд хоёр орны Засгийн газар хамтарч ажиллахаар болсон. Нарийвчлан тооцоо судалгаа хийх дүгнэлт гаргах ажил ид явагдаж байгаа. Гэрээгээр ажиллах хүч гаргах асуудал гацаанд орж 2001 онд нэг ч хүн гаргаагүй байна.

БНСУ-д түр хугацаагаар ажиллах Монгол иргэдийн тоог цаашид нэмэгдүүлэхийг Монголын тал хүсдэг. Энэхүү хүсэлтийг нааштай авч үзэх тухайгаа Солонгосын тал мэдэгдэж, улмаар ажиллагчдын ажиллах орчин, эрүүл мэндийн нөхцлийг нь сайжруулах талаар арга хэмжээ авч буйгаа мэдэгдсэн.

Манай улс 1991 оноос БНСУ-д оюутан, аспирант суралцуулж эхэлсэн. Одоо 90 гаруй оюуоюутан Солонгост сурч байгаагаас 21 нь Солонгосын Засгийн газар болон бусад сангийн тусламжаар, 10 нь сургууль хоорондын тохиролцоогоор, 20-иод нь Солонгосын хувийн хэвшил, олон нийтийн байгуулагын тэтгэлгээр, бусад нь хувийнхаа зардлаар сурч байна. БНСУ-ын 20-иод оюутан манайд сурч байна. Суралцагсдын 90 гаруй хувь нь нийгмийн ухааны чиглэлээр сурч байгаа. Ихээхэн хөөцөлдөж байж олдог сургалтын зардлаар суурь шинжлэх ухаан, нарийн мэргэжлийн хүн бэлтгэх боломжыг алдаж байгаа нь харамсалтай. Мэргэжил сонголт урсгалаар явж байна. Төрийн тэтгэлгээр суралцагсдаас сургуулиа төгсөөд Монгол руу буцдаг хүн ховор. Энэ нь төлөвлөлт бодлогын зохицуулалт алдагдсантай холбоотой юм.

БНСУ Монголын эдийн засгийн хөгжилд туслах зам бол хөрөнгө зээл олгохоосоо илүү чадвартай боловсон хүчнийг бээлтгэх давтан сургах нь чухал юм. БНСУ-ын Засгийн газрын зардлаар жил бүр мэргэжилтнүүдээс гадна эдийн засаг, худалдааны бодлогыг боловсруулдаг ажилтнууд зэрэг олон арван хүнийг сургалтанд хамруулж ирлээ. Зарим үед НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагын зардлаар Яамдын сайд, хот, аймгийн дарга нарыг зах зээлийн эдийн засгийн сургалтанд хамруулж Монголын социалист эдийн засгийн системийг зах зээлийн эдийн засгийн системээр өөрчлөхөд тус нэмэр болж байна. 1990 оны аравдугаар сард Дорно дахины хүрээлэнд Солонгос хэлний сургалт зохион байгуулж, дараа нь Гадаад хэлний дээд сургууль, Техникийн их сургууль, МУИС-д солонгос хэлний тэнхим байгуулахыг санал болгон сурах бичгээр ханган, багш нарыг ажиллуулж байв.

Хүмүүнлэгийн Их Сургуулийн, солонгос, англи хэл, компьютерийн сургалт голлосон “Улаанбаатар коллеж”-д суралцагчид төгсөхөөсөө өмнө ажлын байр олдог аж. Зар мэдээ сонингуудад солонгос хэлний орчуулагч, солонгос хэлтэй ажилчин авна гэсэн зар их болсон. Энэ хэмжээгээр солонгос хэлтэй мэргэжилтний хэрэгцээ их байна. Сүүлийн үед ШУА-ын Олон Улс Судлалын Хүрээлэн Солонгос судлалыг хөгжүүлж судалгааныхаа хүрээгээ тэлж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэллээ.

Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдал, хөгжлийн асуудлыг бид их чухал ач холбогдолтойд үздэг. Энэ үүднээс Монгол Улс энэ бүс

нутгийг хамарсан олон талт хамтийн ажиллагааны бүх хэлбэрийг дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч идэвхтэй оролцох болно.

Холын Солонгос ийнхүү Монголчуудын хувьд худалдаа наймаа бизнесийн үйл ажиллагаа явуулдаг гол төв нь, ажил олж хийж ахуй амьдралаа дээшлүүлэх гэж аяны жолоо залдаг ойрын зам болж хувирчээ.

Харилцаа ингэж өргөжиж байгаа нь баярлууштай хэрэг юм. Цаашид улам хаяагаа тэлж таарна. Нарийн төвөгтэй болж ирнэ. Бие биеийн бодит бололцоо, хэрэгцээ шаардлага зэргийг нарийн тооцож, харилцааны төлвийг хол харж, улам ойр зайнаас хамтарч ажиллах шаардлага тавигдаж байна.

Манай улс тус улстай олон талаар өргөн чиглэлээр хамтран ажиллаж байна. Тэр хэмжээгээр Монгол Улсын гадаад бодлогод эзлэх орон зай жин нөлөө нь улам нэмэгдэж ирлээ. Цаашид хоёр орны харилцаа оновчтой бодлого, уян хатан үйл ажиллагаа, ажил хариуцсан хүмүүсийн хариуцлага гэх мэт олон хүчин зүйлсээс ихээхэн хамаарна. Өөрчлөгдөж байгаа орчин нөхцөл аль аль талын боломж, сонирхол зэргийг бодлогодоо тусгаж шинэлэг санаа арга барилаар идэвхтэй ажиллаж чадвал өмнөх жилүүдийн дунджаас илүү эрчимтэй хөгжих болно.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Ч.Далай “Монгол-Солонгосын эртний түүхэн харилцаа”. УБ, 1998
2. Монгол Улсын Гадаад харилцааны Яамны “Гадаад бодлогын хөх ном”. УБ, 2000
3. Монгол Улс, БНСУ-ын харилцаа 10 жил. 2000
4. ГЯЯ-ны Ази, Америкийн газрын судалгааны материал
5. “Өнөөдөр” сонин. 2002.10.10
6. Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн судалгааны материал
7. ГХЯ-ны Ази, Америкийн газрын судалгааны материал
8. “Өнөөдөр” сонин. 2002.03.13
9. БНСУ-д суугаа Монголын Элчин сайдын Яамны судалгааны материал
10. ГХЯ-ны Ази, Америкийн газрын судалгааны материал
11. Mongolia Consultative Group Meeting. Discussion Papers. 2002 он. Улаанбаатар.
12. “Зууны мэдээ” сонин. 2003.11.26
13. Монгол Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол. 2003 он. №1
14. Мөн тэнд
15. Д.Галсандорж, Х.Буд “Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа, (1291-2000)”. УБ, 2001 он